



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/55

Баянхутаг сум

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дахь заалт, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн "Хамтран ажиллах тухай" 2/1062 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны 05 дугаар сарыг "Түүхэн нутгийн бахархалт соёлын өв – 2025" нөлөөллийн аян болгон зарласантай холбогдуулан "ИДУГАН ЭНТЕРТАЙМЕНТ" ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Хэнтийн мэргэн жаал "ЛАМААДАН" хүүгийн тухай түүхэн уран сайхны киноны зардалд 500.000 /таван зуун мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 500.000 /таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Нягтлан бодогч /Д.Баярмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА



232501055